

ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 1 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар буюу 4-р долоо хоногт нийт Нийслэлийн 8 дүүрэг, 6 аймагт **308** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.

230
Эмнэлэгийн тусламж авч буцсан

77
Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан

1
Нас барсан (сэжигтэй)




Эр **53%** | Эм **47%**

Хүүхэд (0-17 нас) **128**

Насанд хүрэгч (18< нас) **180**

Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 308 тохиолдлын 92% /282/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 8% /26/ нь орон нутагт (Төв /5/, Баян-Өлгий /4/, Орхон /4/, Баянхонгор /3/, Говь-Алтай /3/, Өвөрхангай /3/, Хөвсгөл /2/, Өмнөговь /1/, Булган /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **59** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

4 ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2026.01.18 – 2026.01.24)

2026 оны дөрөвдүгээр долоо хоногт 102 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар буурсан бол 5 жилийн дунджаас 96.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 1-4 дүгээр долоо хоногт нийт 113 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны дөрөвдүгээр долоо хоногт химийн цочмог хордлогод өртсөн **22** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 4.8 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 100 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (4-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	3	7	10
2	Эмийн хордлого	5	7	12
	Нийт	8	14	22

Нийт 22 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 12 (55%) нь эмийн хордлого, 10 (45%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 14 (64%) тохиолдол, санаатай хордлого 8 (36%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.